



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХДАНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар A/108

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4.3 дахь заалт, ШУА-ийн дүрмийн 22-р зүйлийн “е” дэх хэсгийг тус тус үндэслэн ШУА-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө (2018-2025)-г хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь


1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэнгийн эрдэмтэн, судлаач, мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх шинэ хөтөлбөр болох “ШУА-д дадлагжигч-(Intern) хүлээн авах” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг удирдлага болгон ажиллахыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэнгийн удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ШУА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Б.Авид)-д харьяа хүрээлэнгийн захирал нарт даалгасугай

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д. РЭГДЭЛ

23201 0311



“ШУА-Д ДАДЛАГАЖИГЧ (INTERN) ХҮЛЭЭН АВАХ” ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

- 1.1. Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэнгийн эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, ажилчдын мэргэжлийн ур чадвар, хамтын ажиллагааны арга туршлага, олон улсын түвшинд судалгаа, бүтээл туурвих, төсөл хөтөлбөр бичиж хэрэгжүүлэх мэргэжлийн болон хэлний мэдлэг, чадварыг ахиулах асуудал чухлаар тавигдаж байна. Тус хөтөлбөрийн зорилго нь эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтэн нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулахад шинжлэх ухаан, техник, технологи өндөр хөгжсөн улс орны эрдэмтэн, судлаачдыг урьж, ажиллуулах замаар харилцан туршлага солилцож, гадаад хэлний чадварыг дээшлүүлж, ирээдүйн дэвшин суралцах замыг нээн, олон улсын болон дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.
- 1.2. Монгол Улсын Засгийн Газрын “Алсын хараа 2050” урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийн 2.4 олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)-ийн 2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлэх, Шинжлэх ухаан, төхнологийн талаар баримтлах бодлогын 2.2.1, 4.1.2, 4.1.5, ШУА-ийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө (2018-2025)-ний 3.4-ийн хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлээмжийг дээшлүүлэх, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2021 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг үндэслэн “ШУА-д дадлагажигч хүлээн авах” internship хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна.

Хоёр. Зорилго

- 2.1. ШУА болон харьяа хүрээлэнгийн, эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, гадаад хэлний чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох болон цаашдын дэвшин суралцах замыг нээх.
- 2.2. Шинжлэх ухаан технологи өндөр хөгжсөн орнууд болон дотоодын нэр хүндтэй их дээд сургуулиудын ахисан түвшний судлаач, мэргэжилтнүүдтэй мэдлэг туршлагаа солилцох, олон

улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготойгоор олон улсын түвшинд судалгаа, бүтээл туурвиж, төсөл хөтөлбөрт хамрагдах чадварыг ахиулах.

- 2.3.Шинжлэх ухаан технологи, инновацийн төрөлжсөн байгууллагын мэргэжилтэн, судлаачидтай судалгааны тэргүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, харилцан туршлага солилцох.
- 2.4.Шинжлэх ухаан технологийн шинэлэг ололт амжилтаас суралцах, түгээн дэлгэрүүлж нутагшуулах, олон улсад өөрийн байгууллагаа таниулан сурталчлах.
- 2.5.Гадаадын болон дотоодын ахисан түвшний судлаачдын ажлын байрны сонголтод дэмжжээ үзүүлэх, мэргэжилдээ сэтгэл хангалуун чадварлаг боловсон хүчнийг бий болгох, ШУА-тай хамтарсан судалгааг эхлүүлэх зорилгоор дадлага хийх боломжийг олгох.

Гурав. Хамрах хүрээ

- 3.1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, Харьяа хүрээлэнгийн салбар нэгж, лаборатори, хэлтсийг хамарсан байна.
- 3.2. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, Харьяа хүрээлэнгийн салбар нэгж, лаборатори, хэлтсийн бүх удирдлага, судлаач, ажилтан, албан хаагчид тэгш эрхтэй, хариуцлагатай, ёс зүйтэй, эерэг хандлагатайгаар оролцох ба дараах зарчмуудыг баримтална.
 - Судлаачийн ёс зүйг эрхэмлэх
 - Судалгаа хийх, тайлагнах чадвартай
 - Гадаад хэлний ойлголцох түвшний мэдлэгтэй
 - Мэргэжил, арга зүйн мэдлэг ур чадвартай
 - Зохион байгуулалтын ур чадвар өндөртэй
 - Цаг төлөвлөлтийг баримталдаг
 - Багаар ажиллах болон харилцааны ур чадвартай

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

“ШУА-Д ДАДЛАГАЖИГЧ ХҮЛЭЭН АВАХ” хөтөлбөр нь шинжлэх ухаан, техник технологи өндөр хөгжсөн улс орнууд болон Монгол улсын нэр хүнд бүхий их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудаас Шинжлэх ухааны Академи, харьяа хүрээлэнгүүдэд дадлага хийх хүсэлтэй магистр, докторын зэрэгтэй эсвэл тэдгээрт горилогч болон доорх мэргэжлийн чиглэлээр суралцан, ажиллаж байгаа оюутан, мэргэжилтнүүдийг хамруулна. Үүнд:

- Түүх, археологи, угсаатны зүй
- Ургамал, бэлчээр, цэцэрлэгжүүлэлт
- Геологи, структур судлал
- Математик, мэдээлэл зүй, тоон технологи
- Олон улсын харилцаа, орон судлал
- Философи, социологи, нийгмийн сэтгэл зүй, шашин судлал
- Биологи, амьтан судлал, микробиологи, генетик

- Газарзүй, зайнаас тандан судлал, цөлжилт, байгалийн нөөц, геоэкологи
- Одон орон, астрономи, геофизик
- Хими, хими технологи
- Палеонтологи,
- Физик, физикийн технологи
- Шинжлэх ухааны бодлого, менежмент
- Инновац, технологи хөгжүүлэлт

Хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд:

1. Эрдэмтэн, судлаачдын судалгааны шилдэг бүтээлийг орчуулан хэвлүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх
2. Хамтарсан хээрийн болон социологийн судалгаа хийх
3. Мэдээллийн нэгдсэн сан байгуулахад туршлага солилцох
4. Дата анализ, боловсруулалт хийхэд аргазүй, туршлага солилцох
5. Суурь судалгааны хүрээнд хийгдэж байгаа дагалдах ажлуудад оролцох, харилцан туршлага солилцох
6. Статистик программуудыг ашиглан анализ шинжилгээ, боловсруулалт хийх
7. Хамтарсан хурал, семинар зохион байгуулах, санаачлан оролцох
8. Залуу судлаачдад зориулсан илтгэл, лекц унших
9. Гадаадын эрдэм шинжилгээний байгууллагуудтай шинээр хамтарч ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх
10. Судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхэд туршлага солилцох
11. Залуу судлаачдад дэвшин суралцахад холбох гүүр болох

Тав. Удирдлага зохион байгуулалт ба хэрэгжилт, хэрэгжилтийн хугацаа

- 5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг ШУА-ийн ЭНБД удирдах ба зохион байгуулалт, хэрэгжилтийг тэргүүлэгчдийн газрын харьяалагдах хэлтсүүд, Харьяа хүрээлэнгийн удирдлага хариуцна.
- 5.2. Тус хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 жилээр боловсруулан баталж мөрднө. ШУА-ийн тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэнгүүдээс санал авч төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.3. Хөтөлбөрийг хамтын ажиллагаатай гадаад, дотоодын байгууллагуудад зар хүргүүлэх, нээлттэй зарыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан гүйцэтгэнэ.
- 5.4. Хөтөлбөрт хамрагдах судлаачдын хийх ажлын төлөвлөгөө, ажлын хуваарь (хийх ажлын жагсаалт, лекц, сургалт семинарын тоо, ажиллах цагийн хуваарь, үр дүнгийн тайлан) зэргийг хариуцан хүлээн авах нэгж, ахлан чиглүүлэх судлаач зэргийг хариуцах нэгжээс нарийвчлан тодорхойлж удирдамж боловсруулан батлуулж үр дүнтэй, чанартай, харилцан ашигтай зохион байгуулна.
- 5.5. Дадлагажигчийн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 1-3 сар байна.

- 5.6. Дадлагажигчдад тавигдах шаардлага, бүрдүүлэх материал зэргийг дараах хаяг руу илгээх info@mas.ac.mn бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг байгууллагын вэб хуудсаар мэдээлнэ.

Зургаа. Санхүүжилт

- 6.1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэнгүүдээс дадлагажигчийг хариуцан ажиллаж байгаа ажилтанд сарын цалингийн 20%-ийг олгоно.
- 6.2. Дадлагажигчийг ажиллах тохилог орчин буюу өрөө, ширээ, сандал, интернэт орчин, цахилгаан хэрэгсэл, бусад нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 6.3. Дадлагажигчтай хамтын ажиллагааны гэрээг тухайн байгууллагад ирэхээс өмнө байгуулсан байна.
- 6.4 Хөтөлбөрт хамрагдаж байгаа дадлагажигч өөрийн харьяалагдах байгууллагаас замын зардал (тийз- 2 талдаа), ирээд байрлах байр, хоол хүнсний зардлаа бүрэн хариуцна.

Долоо. Дадлагажигч судлаачдад тавигдах шаардлага

- 7.1. Монгол болон гадаад улсын иргэн бөгөөд 65 хүртэл насынх байна.
- 7.2. Гадаад, дотоодын аль нэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын ЭША, магистр, докторын зэрэг горилогч судлаач байж болно.

Найм. Хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

- 8.1.Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж тогтвортой ажиллахад ШУА-ийн Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс, хүрээлэнгийн удирдлага хяналт тавьж, хэрэгжилтийн үнэлгээ хийж, үр дүнг дүгнэж удирдлагад танилцуулна. Үүнд:


- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны доголдол, эрсдэлийг илрүүлж, удирдлагуудад танилцуулах
- Цаашид тогтвортой, үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг хангуулах
- Явцын хяналт-мониторингийг байнга хийх
- Ирж байгаа судлаачидтай байнгын холбоотой байж үйл ажиллагааг жигд, бүрэн явуулах нөхцөл боломж, заавар зөвлөгөөг өгч, хугацаа дуусахаас өмнө, сэтгэл ханамжийн судалгаа авч, цаашид сайжруулах ажлын чиглэл өгнө.
- Улсын бодлого, хөтөлбөр чиглэл, байгууллагын стратеги төлөвлөгөө, дотоод дүрэм журамтай нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

Ес. Хүрэх үр дүн

- 9.1 ШУА болон харьяа хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, цаашдын дэвшин суралцах замыг нээж, олон улсын болон дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 9.2.ШУА-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын бүтээмж, бүтээлийн чанар чансаа ахих, хамтарсан бүтээлүүд гаргах боломж бүрдэж, олон улсад төдийгүй үндэсний хэмжээнд сурталчлан танигдах алхам нээгдэн нийгэм эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулна.
- 9.3. ШУА-ийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж “Олон улсад нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан технологийн үндэсний төв болох” зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үр дүнг үзүүлнэ.

ХЯНАСАН:


УДИРДЛАГА, БОДЛОГО ТӨЛӨВДӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.СУВДАНЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Л.ОТГОНЖАРГАЛ